

Оюутны бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэхэд философийн хичээлийн үүрэг

Г.Эрдэнэбаяр - МУИС. НШУС-ийн сургалтын албаны дарга, доктор
Ж.Каламхас - Дархан-Уул. ТДС-ийн Суурь боловсролын тэнхмийн багш, магистр

Түлхүүр үг: эрүүл сэтгэлгээ, хөдөлмөрч чанар, асуудлыг зөвөөр ойлгох чадвар, уян хатан сэтгэлгээ, азаа сорих зориг, асуудалд бодитойгоор хандах чадвар, хүсэл эрмэлзлэл.

“Боловсролын зуун” хэмээн тунхагласан XXI зуунд манай орны хувьд оюутан залууст мэргэжлийн болон гадаад хэлний өндөр мэдлэг олгохын зэрэгцээ тэдэнд нийгмийн шинэ орчинд дасан зохицож, ажиллаж, амьдрах **бүтээлч сэтгэлгээг** хөгжүүлэх асуудалд онцгой анхаарах хэрэгтэй байна. Учир нь багшлах хугацаандаа хийсэн ажиглалт болон ярилцлага, асуулгын дүнгээс харахад энэ талаархи ихэнх оюутны мэдлэг, ойлголт хангалтгүй бөгөөд энэ асуудалд ерөнхий боловсролын болон их, дээд сургуулиуд ч ач холбогдол бага өгч иржээ. Үний нэг илрэл нь оюутнуудын нэлээд хэсэг аливаа асуудалд хандахдаа бүтээлч бус, бие дааж сэтгэхдээ тааруу, ерөнхийдөө тэдний хувьд бусдыг хуулбарлах, даган дууриах сэтгэлгээ давамгайлж байгаа нь сурлагын чанарт төдийгүй, хүний хөгжилд ч сөрөг нөлөө үзүүлж байгаа юм. Үүний нэг жишээ нь, бүтээлч сэтгэлгээний тухай онол, сургаалуудыг та хэр судалж мэдсэн бэ гэсэн асуултанд судалгаанд хамрагдсан оюутнуудын ихэнхи нь бага зэрэг, 30% нь дунд зэрэг, 13% нь өөрийнхөө хэмжээнд судласан гэж хариулсан болно. Бүтээлч хүн гэж хэнийг хэлэх вэ? гэсэн асуултанд оюутан бүр өөр өөрийн хариултыг өгсөнөөс харахад ихэнхи нь бүтээлч хүн бол цагийг үр дүнтэй ашиглах чадвартай хүн, сэтгэж чаддаг хүн, нэр цуутай алдартнууд буюу Нобелийн шагналтан, идэвхи чармайлттай хүн гэх мэтээр хариулт өгсөн явдал юм.

Өнөөдөр ихэнх оюутнууд орчин тойрондоо юу болж байгааг сайн ойлгохгүй, сайн муу зүйлийг ялгахгүй үнэлэмжийн хоосролд орж, мөн эрэгцүүлэн бодож тунгаах чадвар муу, өөрийгөө илэрхийлж чадахгүй байгаа зэрэг олон зүйлийг анхаарах шаардлагатай байна.

Эргэцүүлэн бодохуйд суралцаагүйн улмаас хүмүүс амьдралдаа олон тооны алдаа төөрөгдлүүд гаргадаг. Үүний жишээ нь, үндэсгүй дүгнэлт хийх, шалтгаан ба үр дагавар, агуулга ба хэлбэрийг хольж хутган төөрөлдөх, асуудалд уян хатан бус хөшүүн хойрго хандах, харилцан буулт хийх чадваргүй байдал гэх мэт олон зүйл байна.

Тэгвэл бүтээлч сэтгэлгээ гэж юу вэ, бүтээлч сэтгэлгээг тодорхойлогч гол шинжүүд юу болох, бүтээлч сэтгэлгээний ач тус юунд орших, оюутны бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэхэд саад болж буй зүйлс, тэрхүү саадыг арилгахад философи ямар үүрэгтэй болохыг энэхүү өгүүлэлд тайлбарлахыг зорилго болгов.

Бүтээлч сэтгэлгээний тухай ойлголт. Юуны өмнө дээд эрэмбийн сэтгэлгээ болох бүтээлч сэтгэлгээний нэг тодорхой жишээ нь философи сэтгэлгээ юм. "Философийн түүх бол "тархины төөрөгдлийг гаргах", хаагдмал байдал, догматизмыг даван туулах хүчтэй хэрэгсэл мөн. Философийн түүх нь асуудлуудын түүх юм. Шүүмжлэлт хандлага болон шүүн тунгаах хүч чадлаа тэлж, ингэснээрээ хурц дайчин бүтээлчээр сэтгэх чадвартай болно. Энэ талаар Липман "Суралцагсад зөвхөн энэ мэдлэгийг мэдэж байна уу, үгүй юу гэдэг нь гол зүйл биш, харин мэдэж байгаа зүйл дээрээ тулгуурлаад эргэцүүлэн бодож чадаж байна уу гэдгийг тодорхойлох нь бидэнд хэрэгтэй"⁸³ хэмээн бичжээ. Философи бол эргэцүүлэн бодох шүүн тунгаах үйл ажиллагаа, мэргэн ухаан, сэтгэлгээний соёл мөн. Ухаалаг хүн бүтээлчээр сэтгэнэ.

Бүтээлч сэтгэлгээ бол үндэслэгээтэй, хянуур, баримттай, шүүмжлэлт сэтгэлгээ юм. Философи нь аливаа санаа сэдлийг олон хувилбараар сэтгэж эрж олдог. Бүтээлчээр сэтгэгчид л шинэ санааг үүсгэж, шинэ зүйлийг эрж олохдоо ямар нэг үзэлд хүлэгдэхгүй чөлөөтэй өөрийнхөөрөө байж чаддаг. Бүтээлч сэтгэлгээ нь бидний өдөр тутмын амьдралын салшгүй нэг хэсэг байх хэрэгцээ улам өсч буй. Бүтээлч сэтгэлгээ нь бидний амьдралыг өнгө оруулж тэтгэгч хүч мөн. Оюутнууд бүтээлч байдлыг амьдралынхаа зуршил болгох хэрэгтэй байна. Тэгж чадвал амжилттай суралцаж, ирээдүйд сайхан амьдрах болно. Н.А.Бердяевийн үзлээр, "Философи сэтгэлгээ нь намайг үргэлж "амьдралын дарамтат уйтгар гуниг болон түүний эрэмдэг зэрэмдэг төрх байдлаас чөлөөлж, надад бүтээлч чанарыг бий болгосон" гэжээ.

Бүтээлч хүн гэдэг бол бүтээлч сэтгэлгээтэй хүн юм. Энэ талаар Харвардын Их Сургуулийн сэтгэл судлаач Пэркинс 1981 онд хийсэн судалгаанаасаа бүтээлч хүмүүс дараах зургаан нийтлэг шинж чанарыг агуулсан байдаг ба энэ шинж чанаруудын хоорондын уялдаа холбооноос бүтээлч хүн төрдөг гэж тогтоожээ. Тэрээр бүтээлч хүн бүр энэ зургаан шинж чанарыг агуулсан байдаггүй боловч энэ шинж чанаруудыг их хэмжээгээр агуулсан байх тусмаа тэр хүн илүү бүтээлч байдаг" гэж бичжээ. Түүний тодорхойлсоноор бүтээлч сэтгэлгээний гол зургаан шинж нь:

1. Хөдөлмөрч чанар. Энэ нь ээдрээтэй олон талт асуудал, тодорхойгүй байдал болон хоорондоо зөрчилдөөнтэй мэдээллийг хүлээн авч боловсруулах, дүгнэх, шийдвэр гаргахдаа уйгагүй хөдөлмөрлөх чадвартай нягт холбоотой. Бүтээлч хүн ийм ярвигтай асуудлуудад хүлээцтэй, нээлттэйгээр ханддаг ба иймэрхүү асуудлыг харин ч дотроо уриалан дуудлага авсан мэт хүлээн авдаг гэнэ. Тэд асуудалд анализ хийж, хамгийн гол цэгийг нь олж тогтоох дуртай бөгөөд өөрсдийнхөө амьдралын утга учрыг ч олж тогтоох, хүрээлэн буй юмсын уялдаа холбоог олох, тэдгээрийг ойлгомжтой болгон хялбарчлах хүсэл эрмэлзэл дүүрэн байдаг. Ийм ч учраас тэд олон талын мэдээлэлтэй харьцан, тодорхой зорилготой ажиллаж, шинэ санаа, шийдвэр олж, өөрчлөлт хийхийн төлөө тэмцэхдээ дуртай байдаг.

2. Асуудлыг зөвөөр ойлгох, тодорхойлох чадвар. Бүтээлч хүмүүс юуны өмнө асуудлыг зөвөөр тодорхойлоход жирийн хүмүүсээс хавьгүй илүү цаг зарцуулдаг болохыг сэтгэл судлаачид тогтоожээ. Асуудлын голыг олж тодотгож,

⁸³ Хүүхдэд зориулсан философи. УБ., 2005. 103 дахь тал

юу мэдэх гэж байгаагаа зөв тодорхойлох нь маш чухал. Тухайлбал, тооны бодлогын яг асуугаад байгаа зүйл болон өгөгдлүүдийг сайн ойлгох, тэдгээр нь хоорондоо авцалдаатай байгаа эсэх зэргийг бодлогоо бодож эхлэхээсээ өмнө сайн эрэгцүүлж ажиглана гэсэн үг юм. Энэ алхамын дараа л асуудлынхаа олон янзын шийдлүүдийг хайж эхэлдэг байна. Зөв асуултыг гаргаж тавьсанаар бид бүтээлч хариултууд, шинэ нээлтүүд хийж чадна. Харин асуултаа буруу тавьбал хариугаа хэзээ ч олохгүй билээ. Философи бол асуулт тавьж, түүндээ хариулах арга ухааныг хүүхэд залуучуудад төлөвшүүлдэг мэдлэгийн салбар билээ.

3. Уян хатан сэтгэлгээ. Бүтээлч хүн урьдах асуудлаа олон талаас нь харж чаддаг бөгөөд зөвхөн өөрийн үзэл бодлоос гадна бусдын дэвшүүлсэн санааг нээлттэйгээр хүлээн авч нухацтайгаар бодож чаддаг. Тэрээр нийтээр хүлээн зөвшөөрсөн ойлголтуудыг үнэн эсэхийг шалгах дуртай. Энэ чадвар нь тогтсон хэв маяг, горим журманд шүүмжлэлтэйгээр хандахад хэрэг болдог байна. Философи бол асуудлыг олон өнцгөөс харж, шүүмжлэлтэй хандах арга сэтгэлгээ мөн.

4. Азаа сорих зориг. Ямарваа нэг зүйл хийж байгаа хүн бүтэлгүйтэх, эсвэл шийдлийг амжилттай олох хоёрын хоорондох нарийн зааг дээр ихэнхдээ ажиллаж байдаг. Бүтэлгүйтэлд хэн ч дургүй боловч бүтээлч хандлага бол үүнийг өөрийнхөө зорилго хүрэх замын нэгээхэн хэсэг гэж хүлээн авах явдал юм. Өөрсдийн бүтээлч чадавхиа эцсийг нь хүртэл шавхан ажиллаж, азаа сорьсноор бид үр дүнд хүрэх магадлалаа өсгөнө. Монгочуудын “Долоо дордож найм сэхнэ” гэдэг үг ч байдаг билээ. Бүтээлч хүн шинэ талбарт гарч, шинэ бололцоог нээх эрмэлзэлдээ хөтлөгдөн азаа сорьдог байна. Бүтэлгүйтэхээс эмээгээд суугаад байвал бид хэзээ ч мөрөөдөлдөө хүрч, хүссэн зүйлээ хийж чадахгүй шүү дээ. Бэрхшээлийн цаана амжилт нуугдаж байдаг билээ.

5. Асуудалд бодитойгоор хандах чадвар. Бодитойгоор хандах гэдэг нь хүн зөвхөн өөрийнхөө л бодлыг ургуулан хөгжүүлээд явахаас гадна бусдын зөвлөгөө, шүүмжлэл, санааг сонсож, харьцуулан үзсэний эцэст илүү зөв үзэл, үнэлэлт өгнө гэсэн үг. Бүтээлч хүн гэдэг зарим хүний боддог шиг орь ганцаардал хүн биш юм. Тэдэнд бусдын учир шалтгаант шүүмжлэл, санаа оноо хэрэгтэй байдаг. Ингэж асуудалд бодитойгоор хандаснаар ямар ч шүүмжлэл, хариу авч сайжруулаагүй бүтээлээс хавьгүй боловсронгуй бүтээл гарч ирнэ.

6. Хүсэл эрмэлзэл, бат итгэл, өөрийгөө цэнэглэх чадвар. Пэркинсийн тодорхойлсон энэ зургаа дахь шинж бол олон судлаачдын үздэгээр бүтээлч сэтгэлгээний хамгийн чухал шинж юм. Бидний хийж буй зүйлд зөвхөн гадны зорилго болох мөнгөн үнэлэмж, цалин, эсвэл одон медалиас гадна уг зүйлийг хийх өөрийн хэрэгцээ сонирхол, дотоод хүсэл тэмүүлэл, өөртөө итгэх итгэл байх хэрэгтэй. Альберт Эйнштейн нэгэн найздаа “Миний өдөр тутмын тэмцэл, хүчин чармайлт минь ямар нэгэн зорилго эсвэл мөрийн хөтөлбөрөөс үүсэн гардаггүй, харин миний өөрийн хэрэгцээнээс үүдэн гардаг” гэж хэлсэн байдаг. Энэ нь уг хүнд өөрийн бодсон зүйлээ хийхгүй суух тэвчээр хүрэхгүй, бүтээлч чадавхиа шавхан хийх сэтгэлийн хүч дотроос нь оргилон гарч ирэхийг хэлж байна гэж би ойлгож байна. Тэр нэгэн зүйлээ хийж биелүүлэх өөрийн дотоод хэрэгцээ, бат итгэлгүйгээр, зөвхөн гадны нэгэн шагнал урамшуулаар хүн нэг хэсэгтээ бүтээлчээр ажиллах боловч ийм байдал удаан үргэлжилбэл тэр хүний бүтээлч чадавхи хатаж үгүй болно.

Харин судлаач Ван Гандийн үзлээр, бүтээлч хүмүүс сониуч зан, бие даасан байдал, өөртөө итгэх итгэл, уян хатан боловч шургуу цөхрөлтгүй зан чанартай байдгаас гадна ямарч асуудалд, ялангуяа тодорхойгүй асуудлуудад хүлээцтэй няхуур хандах буюу яаравчлан өрөөсгөл дүгнэлт хийхээс зайлсхийх чанар, шинэ зүйл, өөрчлөлтийг хүлээн авах чадвартай, таамаглалууд буюу нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн зүйлүүдийг шалгаж үзэх дуртай, юмны хөгжилтэй хошин талыг олж харах чадвартай байдаг гэнэ. Үүнээс гадна тэрээр бүтээлч сэтгэлгээний дараах нийтлэг шинж чанаруудыг чухалчлан тайлбарласан байдаг. Үүнд :

- Анхаарлаа төвлөрүүлэх чадвар болон өөрийгөө мэдрэх мэдрэмж .

Сэтгэлийн хөдлөлд автах үе хэнд ч тохиолдох бөгөөд бүтээлч хандлага бол тухайн эерэг болон сөрөг мэдрэмж нь өөрийн сэтгэлийн хөдлөл төдий эсэхийг танин мэдэхийг оролдох явдал юм. Үүнээс гадна ярвигтай бодлого бодож, бүтээл урлаж, шийдвэр гаргаж буй хэнд ч удаан хугацаагаар анхаарлаа төвлөрүүлэх чадвар шаардагддаг. Ихэнх бүтээлч хүмүүсийн хувьд хийж байгаа зүйлдээ дуртай, түүнийгээ сэтгэлээсээ хийж байгаа бол анхаарлаа төвлөрүүлэх нь нэг их том асуудал биш болж хувирдаг байна. Харин гэд хэзээ анхаарлаа сарниулахаа ч бас мэддэг байна. Хамаг оюун ухаанаа дайчлан ажиллаж, бололцоот бүх арга барилуудыг шавхаад, яавч урагшлахгүй болсноо мэдсэн үедээ хүн өөр зүйл хийх замаар амарч, эргээд сэдэв рүүгээ орох шинэ эрч хүчээ хуримтлуулах нь зөв юм.

- Дайчин зан ба сахилга бат. Асуудалд хүлээцтэй хандах нь зүйтэй ч, үргэлж өөртөө эргэлзээд суух нь мөн л үр дүнгүй. Бүтээлч хүн хэзээ бодлын гинжээ зүсэн гарч, зөн совингоо даган алхам хийхээ мэдэх хэрэгтэй. Энэ нь дээр дурьдсан азаа сорихтой ч холбоотой. Харин сахилга бат бол өөрийгөө захирах сэтгэлийн тэнхээг илэрхийлнэ. Цагийн хуваарь, ирээдүйн зорилго зэргийг төлөвлөсөн бол түүнийгээ баримтлах, эхлүүлсэн зүйлээ дуустал нь үргэлжлүүлэх, биеийн амрыг бодож өөртөө бууж өгөхгүй тэмцэх чанар ч гэж хэлж болно.

- Элдэв шинэ санаагаар тоглох, төсөөллөө ашиглах чадвар. Амарч байх үед ч юмуу, өөр юм хийж байх үед уураг тархины аль нэг хэсэгт гол асуудал, хийж буй зүйл үргэлжлэл орших, шинэ сонин холбоос, шинэ санааг байнга тандан байхыг тоглох гэдгээр илэрхийлж байгаа юм. Мөрөөдөл, ургуулан бодох төсөөллийг жаахан хүүхдийн зан мэтээр үздэг нь бий боловч асуудлаа сэтгэлдээ төсөөлөн харж чадсанаар задлан шинжилгээ хийж байснаас хавьгүй хурдан хариултаа олох нь ч буй.

Одоо оюутны бүтээлч сэтгэлгээг бууруулагч буюу бүтээлч сэтгэлгээний хөгжилд саад болдог хүчин зүйлсийн талаар товчхон авч үзье. Энд олон зүйл бий. Тухайлбал, хувь хүний хичээл зүтгэл дутах, өөрөөр хэлбэл, сэтгэн бодохоос залхуурах, өөрийгөө голох, бусдад тэнэг харагдаж магадгүй хэмээн болгоомжлох, өөртөө итгэлгүй, аймхай, шагнал, урамшуулал авч байгаагүй, бусдыг өөчлөх мөртлөө өөрөө шинэ санаа гаргадаггүй гэх мэт. Эдгээр дутагдлаас салахад оюутан залууст философийн мэдлэг чухал үүрэгтэй. Философи нь оюутнуудад бодож сэтгэх шинэ хэвшил зуршлыг бий болгох, бусдын санаа бодлыг яаран дүгнэж шүүмжлэхээс татгалзах, буруу үзэл бодол, итгэл үнэмшлээсээ салах, өөрийн санаа бодлыг эргэн харж эргэцүүлэн дүгнэх,

мэргэдийн ухааныг өөртөө шингээх, өөрийн болгох, яагаад, ямар учраас гэх зэргээр юмсын мөн чанарыг ухаарах, алсын хараатай байх, сайн муу, сайхан муухай, үнэн худлыг ялгах арга ухаан, чадварыг нь хөгжүүлэхэд туслах үүрэгтэй.

Түүнчлэн Тэрэза Амабил болон Лэс Жоунз нарын сэтгэл судлаачдын үзлээр, хүний бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэхэд дараах зүйлүүд саад учруулах аюултай аж.Үүнд:

1.Бусдаар дүгнүүлэх болон сайшаал урамшууллууд. Эргэн тойрныхондоо, дарга, цэрэгтээ юу гэж дүгнэгдэх бол гэсэн байнгын дарамтанд байдаг хүн дүгнүүлэх шаардлагагүй хүнээс бүтээлч үр дүнгийн хувьд хавьгүй бага байдаг байна. Шүүмжлэл сайшаалын аль нь ч байсан энэ мэт гадны дарамтаас болоод хүний хийж байгаа зүйлээсээ авах дотоод таашаал нь хязгаарлагдана. Асуудалд бодитой хандах үүднээс бусдын шүүмжлэл санаа оноог сонсох нь зөв боловч үргэлж дүгнэгдэх буюу дүн авч сурах нь яваандаа хүнийг хийж байгаа зүйлийнхээ төлөө бус, дүнгийн төлөө ажиллахад хүргэдэг байна.

Энэ байдал оюутны сэтгэлгээнд байнга давтагддаг. Улирлын дүн маань л онц байвал боллоо, хүрч болох хамгийн дээд цэг тэр гэж өөртөө хангалуун явдаг хүн олон бий. Түүгээр ч зогсохгүй уг онц дүнгээ сурч буй материалаа бүрэн гүйцэт мэдэж бус, харин багшийнхаа хувь хүнд, түүний дүн тавьдаг уламжлалд тааруулж байгаад хөнгөн аргаар авах гэж оролддог. Онцоо авбал ямар аргаар авсан нь хамаагүй, өөрийгөө зөв юм хийж байна, их юм сурч байна гэж боддог. Гэтэл тэр ухаант хүмүүн дүнгийн төлөө бус, үнэхээр уг хичээлээ сонирхоод хийсэн бол ямаршуухан бүтээлч зүйл гараас нь гарах байсан бол. Энэ байдалд чанарыг бус, дүнг хамгаас чухалчилдаг багш нарт ч, сургалтын системд ч, мөн сурлагын ба дипломын дүнг чухалд тавьдаг нийгэмд ч буруу бий.

2. Хэн нэгнээс хараат байх. Дарга үргэлж хажууд байж, бидний үйлдэл болгоныг хянаж байхын хэцүүг ихэнх хүмүүс мэднэ. Хэн нэгний хараан доор ажиллах нь хүнд сэтгэлийн дарамт, түгшүүр төрүүлэх ба ингэж ажиллах нь байнгын хараан доор ажилладаггүй юмуу ажиллаж байсан ч үүнийгээ мэддэггүй бүтээлч ажиллагааны хувьд мөн л бага байдаг байна. Үргэлж хянуулснаар бидний бүтээлийн тоо хэмжээ ихэсч болох боловч, бүтээлч чадавхи, шинэ санаа буурдаг. Энэ нь завгүй ажиллахаас илүү завгүй харагдах нь чухал болж хувирдагтай холбоотой болов уу.

3. Хэт өрсөлдөөн. Чөлөөт өрсөлдөөнд бид дуртай. Гэвч хэмжээ нь хэтэрсэн хэт шунаг өрсөлдөөн нь хүний анхаарлыг гол зорилгоос нь хазайлгаж, бодлыг хиртүүлдэг. Өрсөлдөөнд уначихгүй юмсан гэсэн хүн өөрийн хийж буй зүйлээсээ илүү хүний хийж байгаа зүйлийг харах, түүнтэй өөрийгөө харьцуулахад цагаа зарцуулах ба нөгөө дотоод хүсэл эрмэлзэл, асч байгаа гал нь хоёрдугаарт тавигдаж эхэлнэ.

4. Сонголт цөөтэй байх. Ажлаа хийх, өгөгдсөн даалгаврыг биелүүлэх арга хувилбарууд олонтой байж, тэдгээр хувилбаруудаас чөлөөтэй сонгох боломжтой байх тусам бүтээлч идэвхи өрнөдөг байна.

5. Явцуу сэтгэлгээ болон гөжүүд үзэл баримтлал. Явцуу сэтгэлгээ гэдэг нь төсөөлөн бодох ухаанаа өөрөө хаах, тодорхойгүй байдалд орохоос айх болон тогтвортой байдлыг хэт эрхэмлэх, зарим эд зүйл, зан чанар, үзэл

баримтлалаасаа салж чадахгүй байх, хүнийг сонсохоос дургүйцэх болон өөртөө хэт итгэлтэй байх зэрэг юм. Үүнээс гадна өдийг хүртэл хийж ирсэн арга барилдаа хэт их ач холбогдол өгөх юмуу “цагаан эсвэл хар”, “муу эсвэл сайн” гэх мэт туйлширсан үзэл бодолд баригдах нь шинэ хуучин санаануудын хоорондын холбоог олж харах, шинэ санаа дэвшүүлэх, түүнийг дүгнэж, хэрэгжүүлэхэд саад болно.

6. Өөртөө итгэлгүй байх болон өөрийгөө голох. Маш олон хүн төгс төгөлдөр болох гэж хамаг цагаа баран, өөрийгөө голж суудаг. Уг нь өөртөө хатуу хандана, өөрийгөө илүү сайн, илүү ихийг мэддэг, зөв хүн болгох гэж оролдоно гэдэг сайны шинж бөгөөд тэр хүнд бүтээлч чанар байна гэсэн үг. Илүү ихийн төлөө чармайж, өөрийгөө голсноор чанартай сайн бүтээл гаргана. Гэвч энэ зан хэтэрч хийсэн болгон нь сэтгэлд нь хүрэхгүй өөрийгөө голоод эхэлвэл, бүтээлч хүний маань гараас юм гарахаа болино. Өрөөлд тустай зүйл хийхгүйгээс гадна өөртөө итгэх итгэлгүй болж, бүтээсэн зүйлгүй боловч тайван сууж буй хүнд ч атаархмаар хэцүү байдалд орох билээ.

Бүтээлч сэтгэлгээний давуу тал юунд орших вэ ? Асуудлыг олон талаас нь эрэгцүүлэн бодож, шүүн тунгааж үзэх, анхаарлаа сайтар төвлөрүүлэх чадвар, зорилгоо зөв оновчтой тодорхойлох, зорилгодоо хүрэх арга замыг зөв сонгох, өөртөө итгэлтэй, зоригтой байх, өөрийгөө өөрчлөх чадвартай, өөртөө шүүмжлэлтэй ханддаг, бусдын үзэл бодлыг хүндэтгэдэг, ажлыг хойш тавихгүй, шууд тэр дор нь хийх чадвар, эхэлсэн ажлаа дуусгах, шалтаг тоочих өвчнийг эдгээдэг, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх нэг үндсэн хэрэгсэл болдогт бүтээлч сэтгэлгээний давуу тал оршино. Үнэндээ тааруухан амьдралтай хүний бодол сэтгэлгээ нь ч гэсэн тааруухан байдаг тал бий, Амжилтад хүрэх анхны алхам нь бүтээлч сэтгэлгээ мөн. Амжилтгүй байх нь хийж чадахгүйдээ бус, хийж чадахгүй хэмээн бодож сэтгэсэнтэй холбоотой билээ. Идэвхитэй бүтээлч, элбэг баян оюун ухаантай хүн үгүйлэгдэх болсон өнөө үед бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх нь хамгийн чухал гэж үзэж байна.

Дүгнэлт

Ийнхүү хүний бүтээлч сэтгэлгээ нь олон талын мэргэшил, эсвэл авьяас чадвараар тодорхойлогддоггүй байна. Мөн бүтээлийн гоо хэмжээ ч хүний хэр бүтээлчийг тодорхойлдоггүй. Зарим хүн олон тооны, ижил хэлбэр бүтэцтэй бүтээлүүд туурвидаг бол, зарим нь цөөхөн, гэвч бидний амьдралыг өөрчлөхүйц жинтэй бүтээл туурвидаг. Мөн сэтгэн бодох чадвар ч дангаараа хүний бүтээлч эсэхийг тодорхойлдоггүй юм.

Сэтгэн бодох чадвар сайтай боловч бүхэл амьдралынхаа туршид ямарч бүтээлч зүйл туурвидаггүй хүн олон байдаг ба бага IQ-тэй ч он удаан жил бүтээлчээр ажиллаж, амьдарч чаддаг хүн олон байдаг байна. Бид сэтгэн бодохуйгүй сургалтаас гатгалзах цаг болсон байна. Оюутныг бүтээлч сэтгэлгээ, сэтгэн бодохуйд сургахгүйгээр ухаалаг хүнийг төлөвшүүлж чадахгүй. Нийгэмд ухаалаг эрүүл бүтээлч сэтгэлгээтэй хүнийг төлөвшүүлэх хичээлүүдийн нэг нь философи гэдгийг онцлон тэмдэглэе. Ийм учраас оюутнуудыг философи хичээлийг заавал сонгон судлахыг зөвлөж байна.

Ном зүй

- Н.А.Бердяев.Самопознание. М., 1990.с.49
- Mihaly Csikszentmihalyi . Creativity., 1996.
- Howard Gardner . Creating minds., 1993.
- John Michael Fox. Ronni Lea Fox. Exploring the nature of creativity., 2000
- Өөрийгөө хөгжүүлье. УБ., 2004
- Философия для детей. М., 1996.
- Lipman.M.Thinking in Education., Cambridge, N.Y., 1991.